

ТЕРРОРИСТ ХАЛДЛАГЫН ДАРААХИ АНУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ

Ц.Баатар*

Дэлхийн эдийн засгийн өсөлт шинэ зууны гараанд төдий л таатай биш байна. Ялангуяа дэлхийн эдийн засгийн хөдөлгүүрийн үүрэг гүйцэтгэгч АНУ-ын эдийн засаг бүүр ч таагүй байна. Энэ нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж буй гол хүчин зүйлийн нэг боллоо.

Бид АНУ-ын эдийн засгийн өнөөгийн байдлыг өгүүлэхийн өмнө ер нь капиталист систем маань өнөөдөр ямар байдалтай байгааг тоймлон авч үзэх нь зүйтэй болов уу. Учир нь дэлхийн тэргүүлэх эдийн засагтай хөгжингүй орнуудын байдал төдий л таагүй байдалд ороод байгаагийн мөн чанарыг зарим судлаач шинжээчид капиталист системийн өөрт нь хамааруулж үзэх хандлага сүүлийн үед давамгайлж байна. Түүгээр ч үл барам капиталист системийг зоригтой өөрчлөн шинэчлэх асуудал өнөө үед хурцаар тавигдаж байна. Үүнтэй уялдан урьд өмнө байгуулагдсан олон улсын байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааг эргэн харах шаардлага ч гарч байгаа билээ.

Капитализмын өнөөгийн байдал

Капитализмын хувьд сүүлийн жилүүд бууралтын үе байлаа гэж үзэж болох юм. Гэвч 1917 оных шиг биш. Капитализмын эсрэг үзэлтнүүд анх Петербургийн гудамжинд буун дуу гаргаж хувьсгал хийсэн нь Хойд Солонгос болон Кубыг оролцуулахгүйгээр зөвхөн 10 гаруйхан жилийн өмнө л төгсгөл болсон билээ. Wall Street-ийн хөрөнгийн бирж дэх хямрал нь дэлхий нийтийг хамарсан зогсонги байдлыг үүсгэсэн 1929 оны доройтол шиг азгүй тохиолдол юм. Гэвч сүүлийн хямрал үүнээс хөнгөнөөр тусах боломжгүй байлаа. Хэн ч гэсэн өнөөдөр хямрал түүний үр дагаврыг яг таг хангалттай мэдэрч чадаагүй л байна. Гэвч 2001 оны хувьд капитализмд ямар нэгэн дорвитой өөрчлөлт шинэчлэл явагдсангүй.

Дэлхийн зах зээл дээрх нийт хөрөнгө мөнгөний хэмжээ нь / энэ нь бүх хөрөнгө, санхүүгийн зах зээл дээр арилжаалагдсан, хувьцаа ба үнэт цаас / Бостоны Зөвлөх группийн судалгаагаар 2001 онд дөрвөн хувиар унасан байна. Зах зээлийн үнэлгээгээр 250 мянган хөрөнгөтэй

* Ц.Баатар - доктор, PhD

айл өрхийн тоо 39-37 сая хүртэл буурчээ. Ийм учраас өнөөгийн эдийн засаг дэх хөрөнгийн хэмжээ үргэлж өсч, баян нь улам баяжиж байдаг гэдэг хуучны ойлголт өнөө үед учир дутагдалтай болох нь тодорхой боллоо. Техаст төвтэй "Enron" корпорацийн гэнэтийн уналт нь эрчим хүчний салбарын үйл ажиллагаа шударгаар явагддаг гэдэгт итгэх итгэлийг алдагдуулж байна. Доткомын компаниудын /мэдээллийн технологийн компани/ эрчтэй өсөлт, түүний орлого мөн л санхүүгийн булхайн нэг төрөл зүйл байжээ. Үнэндээ бол орлого ихтэй компаниуд нь мөнгийг тэр бүр шударга ариунаар олдоггүй бололтой юм. Америкт бизнесийн эрх ашгийг хамгаалалах хууль тогтоомж нь хөрөнгө оруулагчдад тулгуурласан тэдгээр компанийг илүү их бүтээгдэхүүн гаргаж ашигтай ажиллах бүх талын нөхцөл боломжийг бүрэн хангахад чиглэгдэж ирсэн билээ. "Enron"-ы уналтын дараа хөрөнгө оруулагчид Америкийн олон пүүсийн данс тооцоонд эргэлзэж эхэллээ. Үүнээс харахад Америкийн эдийн засгийн хөгжлийн нэг ёсны загвар болж байсан компаниуд дампуурч байгаа нь дэлхийн капиталист системд түгшүүр төрүүлж байна. Өнөөгийн байдлаар АНУ-д маш их хэмжээний ер пүүсүүдээр дамжин хуримтлагджээ. Үүнд мөн хувийн хэвшлийн жижиг, дунд аж ахуй нэгжүүд ч нэгэн адил хамрагдаж байна. Америкийн томоохон компаниудын талаар ерөнхийдөө өөдрөгөөр харвал хувьцааны үнэ нь маш өндөр хэвээр байна гэж үзсэн тохиолдолд зөвтгөж болох юм. Өнөө хэр гадаадын маш их хөрөнгө мөнгө Америк руу урсан орж байгаа нь зарим нэг ижил нөхцлөөс шалтгаалж байна. Гэсэн хэдий ч Америк одоо санхүүгийн асар их хэмжээний хомсдолд орж байгаа бөгөөд долларыг хүчтэй хэвээр нь хадгалахыг аль байдгаараа чармайн зүтгэж байна. Хэрэв цаашдаа ийм чиг хандлага баримтлах юм бол Америкийн эдийн засаг маш хүнд байдалд орж болзошгүй. Өнөөдөр маш олон орон хөгжлийн Америк маягийн загварыг туршлага болгон ашигласаар л байгаа нь ямар нэгэн онцгой тохиолдолд энэ загвар эргэлзэхэд хүргэж болно. Аргентинд тохиолдсон хүндрэл, бэрхшээл капитализмын дэлхий нийтийг хамарсан их амжилтад аль хэдийн маш аюултай цохилт болсныг дэлхий нийтээр мэдэх боллоо.

Япон шиг зарим нэгэн баян орон хөрөнгийн тэнцвэр алдагдах болон чанаргүй зээлээс сэргийлдэг Америкийн арга барилаас зайлсхийж байна. Арай бага зэрэглэлтэй Европ ч мөн капитализмыг эсэргүүцдэг. Америк маягийн загварыг Азийн нэлээд олон орон, Латин Америк болон хуучин ЗХУ мөн хэзээ ч алс хэтийн тоймтой бодлого

явуулж байгаагүй Африкийн ихэнхи хэсэг, Арабын ертөнц гэх мэт газарт нэвтрүүлээд удаагүй байгаа билээ. Гэтэл өнөө тахин шүтээд байсан загвар маань ийм байдалд ороод байдаг. Энэ бүхэн бидэнд нэгийг өгүүлж анхааруулах дохио санамж болж байна гэлтэй. Юу ч болов дэлхий нийт энэ бүх үйл явцыг анхааралтай ажиглаж байна.

Өнгөрсөн жилийн хувьд капиталист системд өгсөн хамгийн аймшигтай цохилт нь Есдүгээр сарын алан хядагчдын халдлага байлаа. Санхүүгийн систем дэх доголдол нь цаг хугацааны хувьд үүнтэй уялдан зохицсон мэт байсан нь гайхалтай. Дээр нь Америкийн болон илүү өргөн хэмжээтэй дэлхийн эдийн засаг бодож байснаас хоёулаа илүү хүнд цохилтод өртлөө. Террорист халдлага нь аль нэгэн газар капитализмыг маш сайхан зайгуулсан ч гэсэн хэн түүнийг үзэн ядна тэр аль дуртайгаа хийж хорлож болох юм гэдгийг харуулж байна. Энэ алан хядлага нэг их амжилт олоогүй ч тоо хэмжээ, уршигт үр дагаврыг тодорхойлох боломжгүй шинэ аюулыг бий болгоод байна. Терроризмын эсрэг үйл ажиллагааны даатгал нь хориг тавихуйц маш их үнэтэй байна.

Алан хядах үйл ажиллагааг төсөөлөн авч үзэхэд хөгжиж буй орнуудаас одоохондоо нэлээд хол байгаа юм.

Өнөө үед капитализмын ирээдүйн тухай боддог нэлээн том хоёр сургууль байна. Сүүлийн хэдэн жилд болоод өнгөрсөн системийн доголдол нь ялангуяа Америкт болсон гэж үнийг хөөргөдөж тоглодог хүмүүс маргалдаж байгаа бөгөөд ирээдүйг мөн муугаар зөгнөж байна. Тодорхой хэлэхэд үүнд арилжааны захын үнийн хөөрөгдлийн тэсрэлт, түүнчлэн тэргүүлэх компаниудын сүр дуулиантай уналтын учир шалтгааныг дурдахад хангалттай.

Гэвч америкчууд капитализмын хэв маягийг сайжруулахын төлөө маш удаан ажилласан билээ. 1800-д оны сүүлд дээрэмчин язгууртнуудад хяналт шалгалт тавин тэдгээрийн татварын заль луйварт итгэхийн эсрэг үйл ажиллагаа, мөн 1929 оны дараа хөрөнгө оруулагчдыг хамгаалах хамгаалалтыг өсгөх үйл ажиллагаа явуулж байсан, одоо иймэрхүү арга хэмжээг явуулж эхлээд байна.

Энэ бүхнээс үүдэн дэлхийн эдийн засагт муугаар нөлөөлж мэдэх эдийн засгийн хямрал АНУ-д эхэлчихээд байна. АНУ-ын мэдээллийн "World Com" хэмээх томоохон корпораци дампуурсан нь тус улсын эдийн засаг ноштой болж буйн нэг дохио боллоо. Энэ корпораци дампуурсан нь АНУ, барууны бусад орны фондын зах зээлүүд дээр үймээн сандраан тарьж, багагүй хугацаанд хувьцааны үнэ тогтворгүйжин огцом дээшилж, доошилжээ. Америкийн эдийн засагт

хоёр жил орчмын өмнөөс иймэрхүү сөрөг үзэгдлүүд мэдрэгдэж эхэлсэн байна. Арван жил тогтвортой хөгжиж ирсэн Америкийн эдийн засагт 2000 оноос хямрал үзэгдэж эхэлсэн аж. Фондын зах зээлүүд эдийн засгийн үйлдвэрлэлийн сектороос тасарч, хувьцааны ханш тогтворгүйжих байдлаар энэ нь ажиглагдаж эхэлжээ. Фондын зах зээл дээрх байдал өнгөрсөн зууны 20-иод оны сүүлч, 30-аад оны эхээр Америкийг хамарсан тэр уналтын үетэй зүйрлэхүйц байж мэдэхээр сэтгэгдэл төрүүлж байгааг шинжээчид тэмдэглэж байна. Гүн хямралаас зайлсхийхийн тулд төрийн зүгээс ч яаралтай арга хэмжээ авах шаардагдлага ч зүй ёсоор тавигдаж байна. Ерөнхийлөгч Ж.У.Буш АНУ-ын корпорациудын санхүүгийн тайлангийн будлиантай холбоотой дампуурал үймээнийг тус улс богино хугацаанд даван туулж чадна гэж зарлалаа.

АНУ глобалчлагдан буй дэлхийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүчний нэгийн хувьд дэлхий нийтийн эдийн засагт ч энэ базаахгүй байдал нөлөөлж мэднэ гэж эдийн засагчид үзэж байна. АНУ-ын эдийн засаг дэлхийн тэргүүлэх эдийн засгийн нэг гэдгийг бүгд мэднэ.

1997 оны Азийн хямралын дараа дэлхийн улс орнуудын чөлөөт капитал Америкийг зорин урссан билээ. Ноён доллар ч хүчээ авч бусад орны валютыг дарж Америкийн хувьцааны ханш өсч нэг үгээр АНУ-ын эдийн засаг тухайн үедээ үлэмж хүчирхэгжсэн юм. Харин энэ хүчирхэг эдийн засаг одоо түгшүүрийн ирмэгт тулж ирээд байна. АНУ-тай ямар нэг сэжмээр холбоотой бусад орны эдийн засаг ч энэ түгшүүрийн дохиог мэдэрч эхэллээ.

Дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдал

Дэлхийн эдийн засгийн тоймоос харвал Европ төдийгүй Азийн тэргүүлэх орнуудад ч хямралын сүүдэр тусч мэдэхээр байна. Өнгөрсөн оны есдүгээр сард АНУ-д болсон халдлагын дараа манай өмнөд хөрш БНХАУ-ын эдийн засаг дэлхийд бараг ганцаараа огт хөндөгдөлгүй үлдсэн билээ. Өөрөөр хэлбэл тэдний эдийн засаг, санхүү ямар нэг хэмжээгээр уналтад оролгүй хоцорсон. Эдийн засаг нь сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа улс. Гэвч БНХАУ-ын эдийн засгийн хөгжил Америкийн зах зээлийн тогтвортой байдлаас ихээхэн хамаардаг аж. Учир нь БНХАУ АНУ-тай хийдэг худалдааны ашигтай үлдэгдлийн хэмжээгээр толгой цохидог юм байна. Манай гол хандивлагч Японы эдийн засаг ч АНУ-тай холбоотой. Япон улс АНУ-д автомашин, телевиз, бусад цахилгаан барааг ихээр нийлүүлдэг. Америкийн зах зээл ганхвал

Хятад, Япон хоёр ихээхэн хохирол амсана гэж эдийн засагчид дүгнэжээ. Европ тив дэх манай гол хандивлагч Германы эдийн засаг ч таагүй нөхцөлд байгаа аж.

Манай хойд хөрш ОХУ Америкийн эдийн засагт болж байгаа үйл явцыг түгшүүртэйгээр ажиглан харж байна. Оросын эдийн засаг глобалчлалд нэвт автаж, дэлхийн зах зээлийн аливаа сөрөг өөрчлөлтийг гүнзгий мэдэрдэг болжээ. Оросын хөрөнгийн биржүүд Америк маягаар ажиллаж байгаа учир үзүүлэлтүүд нь АНУ-ын эдийн засгийн байдал төлвийг илтгэдэг болсон аж. Долларын ханш унавал ОХУ-ын төв банкны валютын нөөцөд ноцтой цохилт болно гэж "Риа Новости" агентлагийн тоймд дурджээ. Дэлхий нийтээрээ нефьтийг ам.доллараар үнэлдэг тул долларын ханш буувал нефьтийн үнэ унаж газрын тосны гол экспортлогчийн нэг ОХУ хохирч таарна гэж Оросын шинжлэх ухааны академийн Олон улсын эдийн засаг, улс төр судлалын институтын ерөнхий шинжээч, профессор А.Быков бичжээ. АНУ-ын гаалийн татвар, хураамж өссөнөөс болж ОХУ-аас Америкт төмөрлөг нийлүүлэхэд хүндрэлтэй болсон бөгөөд Америкийн зах зээл уналтад орвол энэ боломжоо бүр алдаж ч мэдэх аюультай байдалд орлоо. Ийнхүү тэргүүлэгч эдийн засагтай их гүрний санхүүгийн хямрал олон оронд нөлөөлж болзошгүй нь гэж төсөөлж болохоор байна.

Америкийн эдийн засгийн өнөөгийн байдал

Дайны хажуугаар дажин гэгчээр сүүлийн үед Америкийг төдийгүй дэлхий нийтийг донсолгосон санхүүгийн дуулиант хэрэг ар араасаа хөврөн гарч Америкийн санхүүгийн алдагдлыг улам ч хурдасгаж байгаа нь дэлхий нийтэд түгшүүр төрүүлж эхэллээ.

Энэ оны зургадугаар сарын сүүлч буюу АНУ-ын тусгаар тогтнолын баярын өмнөхөн Америкийн телефон холбооны хоёр дахь том компани болох "World Com" корпорацийн санхүүд хийсэн шалгалтаар тэдний санхүүгийн ажилтнууд нягтлан бодох бүртгэлийг будлиантуулж, 2002 оны эхний улиралд дарвөн тэрбум орчим ам.долларын алдагдлыг хувь нийлүүлэгчид болон зохих байгууллагуудаас "нууж" байсан нь илэрсэн юм. Энэ шуугиан дорхноо санхүүгийн зах зээлд нөлөөлж, Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр Доу Жонсны индекс бараг 200 пунктаар унасан байна.

Иймэрхүү хүнд уналт урьд өмнө хэзээ ч тохиолдож байгаагүй бөгөөд үүнийг шинжээчид Америк оронд бөмбөг тэсэлсэнтэй адилтган зүйрлэж байгаа юм. Учир нь Америкийн эдийн засгийн хүчин чадал нь

хөрөнгийн зах зээл дээр тогтдог. Энэ зах зээл дээр 1990 оны сүүл үеэс хойш америкийн компаниудын хувьцааны үнэ эрс өсч, АНУ-ын нийт эдийн засгийн байдал сайжирсан. Хөрөнгийн зах зээл дээр хамгийн гол нь итгэл байдаг. Хүмүүс компаниудад итгэж хувьцааг нь худалдан авдаг. Харин корпорациуд эдгээр хүмүүсийн хувьцаа худалдан авсан "сул" мөнгийг өөрсдийн бизнест эргэлдүүлэн үржүүлж, корпорациаа санхүүжүүлэх, илүү гарсан ашгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилах замаар харилцан ашигтайгаар бие биеэ нөхөн амьдардаг.

Техасын эрчим хүчний "Enron" корпораци мөн ийм санхүүгийн будлианаас болж саяхан дампуурсан нь санхүүгийн тэргүүлэх захуудыг цочирдуулсныг бид дээр өгүүлсэн. Тэр ч бүү хэл монголчууд бидний сайн мэддэг Монголын аудитын компаниудыг нэр алдраараа далайлган сүрдүүлэгч томхон компанийн аудитын үйл ажиллагааг дангаараа хийж Монголдоо монопол тогтоож байсан аудитын "Артур Андерсен" компани хүртэл энэхүү дампууралтай холбоотой баримтуудыг нууж хаасан нь илчлэгдэж, гал дээр тос нэмсэн. "World Com" корпорацийн дуулиан нь "Enron" корпорацийн дампуурлын дараа тэртэй тэргүй ганхаж эхэлсэн америкийн компаниудад итгэх итгэл рүү улам их ус цацсан явдал боллоо гэж мэргэжилтнүүд үзэж байна.

"World Com" корпорацийн хувьцааг борлуулдаг "NASDAQ" электрон биржид тус корпорацийн хувьцааны гүйлгээг зогсоон өөрийн үйлчлүүлэгчдийн жагсаалтаас хасах тухай асуудал ярьж байна. 1999 оны зургадугаар сард 64 ам.долларын үнэтэй байсан "World Com"-ын хувьцааны ханш 2002 оны зургаадугаар сарын сүүлчээр 83 цент хүртлээ унахад "NASDAQ" электрон биржээс арилжааг нь арга буюу зогсоожээ.

"World Com" корпорацийн булхайны цар хүрээ. "World Com" корпораци нь АНУ-ын Миссисипи муж улсын Клинтон хотод байдаг, 80 мянга гаруй ажиллагсадтай, интернетэд 20 сая гаруй үйлчлүүлэгчдэдтэй бөгөөд АНУ-ын харилцаа холбооны томчуудын нэг "Эм Си Эй" групп, интернетийн нэлээд хэсгийг хяналтдаа байлгадаг "ЮЮ Нэт" компанид харьяалагддаг. Энэ нь манай зах зээл дээр бол Монголын Цахилгаан холбоо, Мобиком л гэсэн үг. "World Com"-ын тайлан балансад тусгагдаагүй дөрвөн тэрбум ам.долларын алдагдал гэхэд л Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүнээс дөрөв дахин хол давж гарна. Энд мөн дээрх корпорацийн гүйцэтгэх захирлууд болон

топ менежерүүдийн сайн ажилласны төлөө авч байсан хэдэн арван сая ам.долларын асуудал ч яригдаж байгаа юм.

Үүгээр ч зогсохгүй ашгаа хуурамчаар өндөрт барьж, хувьцааны үнийг хөөрөгдөж байснаас тус корпорацийн хувьцаа эзэмшигчид олон тэрбум доллараар “шатаж” байна. Хамгийн аюултай нь америкийн хөрөнгийн зах зээлийг бүрхээд байгаа үл итгэх уур амьсгал ойрын үед сарнихгүй бол америкийн компаниудын хувьцааг эзэмшигч хөрөнгө оруулагчид олон зуун тэрбум доллараар хохирч болзошгүй гэж шинжээчид үзэж байгаа.

Одоогоор “World Com”-ын өр 30 тэрбум болж, тус корпораци 17 мянган ажилтнаа халахаар зарласан. Корпорацийн шинэ удирдлага зардлаа жилд 2 тэрбум гаруй доллараар багасгана гэж төлөвлөж байгаа ч дампуурлаа зарлах нь цорын ганц зөв гарц гэж олонхи мэргэжилтнүүд үзэж байгаа юм.

АНУ-ын засаг захиргааны “реакц”. АНУ-ын Ерөнхийлөгч Жорж У.Буш ард түмэндээ хандан хэлсэн үгэндээ “World Com” корпорацийн үйлдлийг “жигшүүрт” хэрэг хэмээн тодорхойлж, Америкийн засгийн газар энэ хэргийн учрыг бүрэн олж, гэм буруутай этгүүдүүдийг шийтгэнэ гэж амласан байна. Мөн тэрээр “Америкийн бизнесийн үнэн ариун байдалд итгэх итгэлийг эргүүлэн авчрахын тулд хууль дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах”-ыг уриалан дууджээ.

Америкийн бизнесийн үнэн ариун байдлыг эргүүлэн авч ирэхэд дараахи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг Ерөнхийлөгч Ж.Буш санал болгосон юм. Үүнд:

- Санхүүгийн арга заль, луйварт буруутай корпорацийн удирдлагыг шоронд хорих хугацааг 5-10 жил болгон уртасгах;
- Хууль зүйн яамны дэд сайдын хяналтын дор корпорациуд дахь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай байгууллага байгуулах;
- Сэжигтэй арилжаа хийсэн топ менежерүүдийн дансыг түр хаах, саатуулах эрхийг Үнэт цаас, биржийн комисст олгох;
- Үнэт цаас, биржийн асуудал хариуцсан комиссын төсвийг 100 сая доллараар нэмэгдүүлэх;
- Корпорациудын удирдлага өөрийн өндөр албан тушаалтнуудад хөнгөлөлттэй зээл олгохыг болиулах;
- Компанийн захирлуудын зөвлөлийн ихэнх гишүүдийг уг компанитай материаллаг сонирхолгүй, шууд хамааралгүй хүмүүсээр бүрдүүлэх зэрэг болно.

Ж.Буш америкийн олон нийтэд хандаж энэ оны 7-р сарын 10-нд Wall Street-д үг хэлэх үеэрээ дэвшүүлсэн дээрхи саналыг Америкийн бизнесийн элитүүд төдий л таатай хүлээж авсангүй. Түүнийг үг хэлэх үеэр Нью-Йоркийн хөрөнгийн биржийн Доу-Жонсын индекс байрандаа эргэлдэж байснаа дууссаных нь дараа доошилж эхлээд бирж хаагдах үед 178 пунктээр унаж, сүүлийн таван жилд хамгийн доод түвшинд очжээ. Энэ нь америкийн бизнес элитүүдэд Ерөнхийлөгчийн үг нэг их сэтгэгдэл төрүүлээгүйг харууллаа гэж америкийн хэвлэлүүд дүгнэж байна. "Хэрэв хэн нэгнийг үнэхээр шоронд суулгавал олон нийт корпорациудад арай өөрөөр хандаж магадгүй" гэж Nasdaq биржийн удирдлагуудын нэг Жак Фрэнсис үзэж байна.

Бостоны нэрт өмгөөлөгч, корпорацийн эрх зүйгээр мэргэжсэн шинжээч Уильям Кинг энэ талаар "Би одоогийн засаг захиргааг авилгалд идэгдсэн гэж хэлэхгүй ч Бүгд найрамдах намынхан цөмөөрөө л бизнесийн том бүлэглэлүүдэд ойрхон байсан. Ерөнхийлөгч Буш ч, дэд ерөнхийлөгч Чейни ч тэр, бизнесийн энэ ертөнцөд том албан тушаал хашиж байсан. Тэгэхлээр санхүүгийн энэ дуулиан шатсан хоёр гурван бизнесменийг гаргуунд нь гаргаснаар дуусч магадгүй. Тэд корпорациудын луйврыг таслан зогсоох ямар нэг шинэ бүтцийг бий болгох магадлал багатай. Харин тэдний энэ хандлагыг ардчилсан намынхан улс төрийн зорилгодоо ашиглах нь мэдээж" гэж дүгнэжээ.

Ерөнхийлөгчийн үг хэлсэн тэр өдөр АНУ-ын ардчилсан намынхан саяхан дампуурсан "World Com". "Enron" корпорациудын хувьцаа эзэмшигчид, халагдсан ажилтнуудыг цуглуулж эсэргүүцлийн цуглаан зохион байгуулжээ. Уг цуглаан дээр ардчилсан намын Сенат дахь олонхийн ахлагч Том Дэшл олон нийтэд хандаж "Санхүүгийн тайлан, ня-бо бүртгэлийн тухай хангалттай ярилаа. Харин Ерөнхийлөгч одоо энэ хууртагдсан хүмүүсийн уур хилэнг хуваалцах ёстой" хэмээн мэдэгджээ.

Санхүүгийн дуулиантай холбогдуулан АНУ-ын Үнэт цаасны комисс эргэлтийн хөрөнгө нь 1,2 тэрбум доллараас давсан америкийн компаниудын топ менежерүүдэд хандсан тогтоол гаргажээ. Уг тогтоол ёсоор тэд санхүүгийн тайлан нь үнэн зөв, шударга хийгдсэн гэдгээ тангараглах болж байна. Үнэт цаасны комиссын жагсаалд ийнхүү тангараг өргөх 947 компани бүртгэгдсэн ч хэрэг дээрээ ийм эргэлттэй компани хэд дахин их байгаа аж. Учир нь дээрх тогтоол нь оффшор бүсэд бүртгэлтэй компаниудад үйлчлэхгүй гэнэ. Гэтэл Бермудын болон Багамын арлуудад албан ёсны бүртгэлтэй ч үйл ажиллагаагаа АНУ-д

явуулдаг олон тэрбум долларын эргэлттэй компаниуд олон байдаг.

Мөн корпорацийн боссуудыг "илчлэхэд" АНУ-ын Үндсэн хуулийн тавдугаар нэмэлт заалт ихээхэн саад болж байгаа гэнэ. Америкийн ардчиллын билэг тэмдэг ч гэгддэг, заримдаа ямар ч утга учиргүй, үеэ өнгөрөөсөн заалт ч гэгддэг энэ нэмэлтэд "АНУ-ын иргэн өөрхийнх нь эсрэг ашиглаж болзошгүй асуудлаар мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй" гэж заасан байдаг. Нэг хэсэг энэ нэмэлтийг "коммунистуудын тавдугаар нэмэлт" гэдэг байжээ. Учир нь хүйтэн дайны үед АНУ-ын коммунист намын удирдагчид энэхүү заалтыг ашиглан коммунист намын үйл ажиллагааны талаар мэдүүлэг өгөхөөс татгалзаж хэрэг явдлаас эвтэйхэн мултарч гардаг нэг ёсны хамгаалалтын найдвартай бамбай болдог байж.

Тэгвэл саяхан дампуурсан эрчим хүчний "Enron" корпорацийн ерөнхийлөгч Кеннет Лей конгресст мэдүүлэхдээ: "Би өөрийн компанид болсон бүх үйл явдалд гүнээ харамсаж байна. Би бүх асуултад хариулахыг хүсч байгаа боловч харамсалтай нь миний өмгөөлөгчид Үндсэн хуулийн тавдугаар нэмэлт заалтад заасан эрхээ эдлэхийг зөвлөсөн. Гэхдээ намайг энэхүү хууль ёсны эрхээ эдэлснийг минь хэн нэгэн нь намайг ямар нэг нуух юмтай байна гэж бодох вий гэдэгт миний санаа ихэд зовж байна" гэжээ. "Артур Андерсен" компанийн ерөнхий ня-бо нар, "World Com" корпорацийн хоёр ч удирдагч мөн энэ зарчмаар мэдүүлэг өгөхөөс татгалзсан байна. Тэд эхлээд конгрессын гишүүдийн өмнө босч, гараа өргөн "Үнэнийг, зөвхөн үнэнийг ярих болно" хэмээн тангараглаад, дараа нь Үндсэн хуулийн тавдугаар заалтыг сануулан ямар нэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан ажээ.

Ийнхүү АНУ-ын Үндсэн хуулийн 5-р нэмэлт заалт санхүүгийн луйварт оролцогчдыг хамгаалах нэг ёсны бамбай болж байна.

Америкийн дээдэс ба санхүүгийн луйвар

АНУ-ыг шуугиулж байгаа санхүүгийн дуулиант хэрэгт одоогийн ерөнхийлөгч Жорж У.Бушийн нэр шууд хөндөгджээ. Америкийн тэргүүлэх корпорацуудын удирдлага хөрөнгө оруулагчдыг мэхэлсэнтэй холбогдон мандсан шуугианд 1990 онд Ж.У.Буш Техасын нефтийн "Харкен энерги корп" корпорацийг удирдаж байх үедээ тус корпораци дахь өөрийн мэдлийн багц хувьцааг зах зээлд үнэ нь унахаас өмнөхөн борлуулсан асуудалд өртсөн байна. Хамгийн гол нь Ж.У.Бушийг тус корпорацийн 850 мянга орчим ам.долларын үнэтэй багц хувьцааг худалдахдаа Холбооны улсын үнэт цаасны комисст хуулийн дагуу зохих

ёсоор мэдэгдээгүй гэж яригдаж байна. Тухайн үед "Харкен энерги корп" корпораци 23 сая ам.долларын алдагдал хүлээсэн тухай зарлахын өмнөхөн Ж.У.Буш багц хувьцааныхаа ихэнхийг худалдсан бөгөөд дээрх алдагдлын тухай зарлангуут л нэгж үнэ нь дөрвөн ам.доллар байсан хувьцааны үнэ нэг ам.доллар хүртлээ унасан аж. Харин одоогийн ерөнхийлөгч Холбооны улсын үнэт цаасны комисст багц хувьцаа худалдсан тухай баримт бичгийг өгөхдөө "Харкен энерги корп" корпорацийн хуульчид алдаа гаргаснаас биш би гаргаагүй гэж нотолж байгаа гэнэ. Тэр үед хяналтын байгууллагууд дээрх багц хувьцааг худалдсан нөхцөл байдлыг шалгаад эцэг нь АНУ-ын Ерөнхийлөгчийн албыг хашиж байсан бага Жорж Бушийн эсрэг хэрэг үүсгээгүй өнгөрсөн юм байна.

Ерөнхийлөгч Жорж У.Бушийн араас санхүүгийн дуулиант хэрэгт АНУ-ын дэд ерөнхийлөгч Дик Чейни нэр холбогдлоо. Дик Чейни 1995-2000 онд нефть олборлох салбарт барилга инженерийн төсөл боловсруулдаг, зөвлөлгөө өгдөг "Halliburton" гэдэг корпорацийг удирдаж байжээ. Энэ корпорацийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн АНУ-ын Үнэт цаасны комиссын урьдчилан мэдэгдсэнээр тус корпораци 1998 онд барилгын төслүүдийнхээ өртгийг зориуд өсгөсөн байж магадгүй гэнэ. Харин Дик Чейнигийн эсрэг хувьцаа эзэмшигчдийг төлөөлж олон нийтийн хяналтын "Judicial Watch" гэдэг байгууллага зарга мэдүүлээд байна. Өөрсдийгөө "Олон түмний хууль зүйн яам" хэмээн нэрлэдэг тус байгууллагынхны үзэж байгаагаар 1998 онд "Halliburton"-ны ня-бо нар дээд удирдлагаасаа барилгын томоохон төсөлтэй холбоотой зарим төлбөрийг корпорацийн орлогод авах тушаалыг авсан байна. Гэтэл энэхүү төлбөр гээч нь гүйцэтгэсэн ажлын төлбөр бус харин төсөв хэтэрсэн тохиолдолд хийх нэмэлт санхүүжилт байсан аж. Ийнхүү тус корпораци орох эсэх нь тодорхойгүй орлогыг урьдчилан бүртгэснээр "Halliburton" корпорацийн орлого хиймлээр өсч, ашиг нь бодит байдлаас илүү харагдаж, хөрөнгө оруулагчдыг төөрөгдүүлэн хувьцааны үнийг хөөрөгдүүлж байжээ.

Заргын мэдүүлэгт Дик Чейнигээс гадна "Halliburton" корпорацийн бусад удирдлагын нэрс, мөн "нөгөө" л "Артур Андерсен" компанийн нэр тууж явна. Энэ бүх үйл явдлын талаар Дик Чейни өөрөө болон Цагаан ордны зүгээс одоохондоо ямар нэг мэдээлэл хийгээгүй байна. Харин "Halliburton" корпорацийн төлөөлөгчид дээрх заргыг ямар ч үндэслэлгүй зүйл гээд хэрэв энэ асуудлаар шүүх хурал болбол тэр нь ямар ч "ирээдүйгүй" гэж мэдэгджээ. Гэвч дэд ерөнхийлөгчийн

нэр дээр ийм будлиан зарга үүссэн нь өөрөө том дуулиан гэж Вашингтонд үзэж байгаа юм. Ялангуяа долдугаар сарын 10-ны өдөр Ерөнхийлөгч Жорж У. Буш Wall Street-ийн бизнесменүүд, банкируудтай уулзаж уг хэлсний дараа Чейнигийн нэр дээр ийм зарга үүссэн нь улам шуугиан тарьж байна. Уг уулзалт дээр Ерөнхийлөгч Жорж У. Буш "Манай засаг захиргаа үнэнийг нуудаг, баримтыг хуурамчаар үйлддэг, хуулийг зөрчдөг энэ үеийг дуусгахын тулд бүхнийг хийнэ" гэж амласан юм.

Гэсэн хэдий ч дээр өгүүлсэн АНУ-ын Үндсэн хуулийн тавдугаар заалтыг гул барьж өөрийн эсрэг мэдүүлэг өгч нэр төр, бизнесийн эрх ашгаа сэвтүүлэх эр зоригтой бизнесмен олдох нь одоохондоо юу л бол.

АНУ-ын Засгийн газар "World Com" корпорацийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэлээ. "Америкийн корпорациудын тайлан тэнцэл зарим талаар сэтгэл түгшээж байна. Хүмүүс бүрэн эрхээ хэтрүүлэх тохиолдол олон байдаг ч Америкийн Үнэт цаасны асуудал хариуцсан комисс болон Засгийн газар энэ бүгдийг ажиглаж байдгийг тэд мэдэх ёстой" хэмээн Ерөнхийлөгч хэлжээ.

Америкийн корпорациудад итгэх итгэлийг алдагдуулж буй дээрх шинэ дуулиант хэрэг АНУ-ын санхүүгийн зах зээлд сөрөгөөр нөлөөлж буйд сэтгэл түгшиж байгаагаа Канадад "Их найм"-ын дээд хэмжээний уулзалтад оролцох үедээ Ж. Буш илэрхийлсэн байна.

Санхүүгийн луйврын эх үндэс. Швейцарийн "Le Temps" сонинд өгүүлэхдээ, "World Com" корпорацийн хэрэг бол дуулиан шуугиан биш харин сүүлийн арваад жилд хэвийн зүйл болсон гаж үзэгдлийн илэрч гарч ирсэн баримт юм гэжээ. Тэдний үзэж байгаагаар "Санхүүгийн тайлан тэнцэлд хийгддэг нарийн төвөгтэй заль мэх нь санхүүгийн луйварчид бизнесийн дээд ертөнцөд аль хэдийнээ орж ирснийг харуулж байгаа юм. Сүүлийн арваад жил санхүүгийн "босс"-уудыг баялгийг бүтээгчид, урьдчилан зөгнөгчид, өглөгийн эзэд мэт өөгшүүлж ирсэн нь тэд өөрсдийгөө хэт үнэлж, хууль ёсноос дээгүүр тавьж, тэдний үйл хөдлөлийг хэн бугай ч хянах аргагүй тийм байдлыг үүсгэсэн юм" гэж дүгнэсэн байна.

Энэ бүгдийн эхлэл нь социалист системийн задрал, хуучин ЗХУ-ын уналттай холбоотой гэнэ. Өнгөрсөн зууны 70-аад оноос барууны ертөнц төрийн оролцооны зарчим, дүрэм ёсыг үгүйсгэж, чөлөөт зах зээл, бизнесийн эрх чөлөөг хэт эрхэмлэснээс сүүлийн хориод жил нийгэм бүхэлдээ ашиг олохыг хичээж, аливаа дүрэм журмыг хөгжлийн саад тотгор мэт үзсээр ирсэн. Үр дүнд нь капитал чөлөөтэй эргэх болж

олон улсын зах зээлд шуурхайлан орсон байна.

Шинэ технологийн үрээр орон зай хумигдаж, шинэ зах зээл үүсч, эдийн засгийн шинэ тайз бий болж, түүн дээр хэмжээгүй эрхт "капитал" тоглож эхэлсэн байна. Яг энэ үед ЗХУ задарч, "проблем" эхэлжээ. Либерализмын доктор ОХУ-д муужруулах эмчилгээ бичиж өгчээ. Энэ эмчилгээний гол заалт нь "хувьчлах, хувьчлах бас дахин хувьчлах", гэхдээ төрийн монопольт том компаниудыг задлалгүйгээр байгаа чигээр нь хувьчлах шийдвэр гаргав. ОХУ дахь хувьчлал нь эрхэм "капитал"-ын хувьд "Зууны наймаа" болсон бөгөөд энд аудитын компаниуд, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, үндэстэн дамнасан корпорациудын удирдлагууд ханцуй шамлан орсон байна. Энэ үеэс "Хүчтэй нь хүчгүйгээ барьж иддэг балар эртний жунглийн зарчим"-ыг зах зээлийн хууль мэтээр хүлээн авсан. Юу болж буйг бүгд мэдэж байсан ч энэ бүхэн ердийн үзэгдэл мэт бодох болжээ. Бүгд энэ зах зээл дээр хамтран тоглож, корпорациуд нэгдэн нийлснээр бирж дээрх хувьцааныхаа ханшийг хиймлээр хөөрөгдөж байсан бөгөөд энэ бүгдийг зогсооно гэвэл асвэл бурхан болох, эсвэл цаг үеэсээ хоцрогдсон нэгэн болох шаардлагатай байсан юм" гэж Швейцарийн "Le Temps" сонинд бичсэн байна.

Дээрх дүгнэлт нь америкийн капитализм өнөөдрийн энэ дуулианы эхлэлийг өөрөө тавьсан гэсэн логик санааг агуулж байна. "World Com", "Enron" компаниудын санхүүгийн луйврын үр дагавар АНУ-ын эдийн засагт аль хэдийнэ сөрөгөөр нөлөөлж эхлээд байгаа юм. Тухайлбал, эрчим хүчний "Enron" компанийн буруутай үйл ажиллагаанаас болж, Калифорни муж улс 30 тэрбум долларын алдагдал хүлээжээ.

1929 онд болсон эдийн засгийн их хямралаас болж америкчууд Нью-Йоркийн хөрөнгийн биржийг №1 дайсан гэж үзэж байсан баримт байдаг. Өнөөдөр америкийн систем өөрт нь итгэх итгэлийг буцаан олж чадах уу? Өөрөө өөрийгөө засч эрүүлжүүлэх чадвартай юу? гэсэн асуулт тавигдаж байгаа юм. Статистикийн үзүүлэлтээс харахад 1997-2001 онд АНУ-ын төрийн байгууллагуудын зүгээс санаачлан санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн эсрэг мэдүүлсэн заргын тоо 1669-3538 хүртэл өссөн нь америкийн нийгэм энэ бүхэнтэй хүчтэй тэмцэл явуулж байгааг харуулж байна.

Америкийн эдийн засгийн талаар санхүүгийн дуулиант хэрэг гараагүй байхад судалгааны гол гол төвүүд, судлаачид шинжээчид хэрхэн юу бичиж байсныг одоогийн байдалтай харьцуулан үзэхэд хэрэгтэй байж болох тул бид энд энэ талаар товч өгүүлье.

Таамаглал ба бодит байдал

Энэ оны I улиралд *Blue Chip Economic Indicators* хэмээх эдийн засгийн урьдчилсан таамаглалын тэргүүн мэдээнд, эдийн засгийн 53 тоймчийн мэдээг оруулжээ. Тэдний 70 хувь нь дөрөвдүгээр сарын сүүлээс хэтрэхгүй уналт зогсоно гэж бодож буйгаа илэрхийлсэн байна.

Олонхи эдийн засагчид энэхүү өвөрмөц уналтыг ойлгохгүй байгаа гэсэн үнэнийг бас хэлэх ёстой. Тэдний олонхи нь шочир сонин болсон энэ уналтыг урьдчилан хараагүй, яагаад гэвэл өмнөх цэцэглэлтийн мөн чанарыг ойлгоогүй байжээ гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч өмнөх өсөлтийн хүчин чадлыг хэтрүүлэн үнэлсэн хэвээрээ байгаа. Түүний зүтгүүлэх хүч болж байсан үрлэг зарлага ихтэй хөрөнгө оруулалтууд ялангуяа хөрөнгийн биржүүд дэх булхай зэрэг нь бүхэлдээ өрөвдөлтэй дорой байсныг хожуу ч гэсэн хүлээн зөвшөөрсөн юм.

Өнгөрснөө эргэн харъя. 1996 оны нэгдүгээр сард Блю Чипийн мэдээлэлд ДНБ 2,2 хувь өснө гэж байжээ. Тэгвэл тэр жилийн жинхэнэ өсөлт нь 3,6 хувь болсон билээ. 1997 онд 2,3 хувь таамаглаж байсан бол амьдрал дээр 4,4 хувь өсөж, 1998 онд 2,5 хувь байсан бол 4,3 хувь болж, 1999 онд 2,4 хувь гэж таамагдаж байсан бол 4,1 хувь, 2000 онд 3,6 хувь гэж таамаглаж байсан бол 4,1 хувь болж тус тус өссөн билээ. Эдгээрийг ялихгүй зүйл хэмээн үзэж хэдхэн хувиар алдсан байна гэж хэлж болох юм. Гэтэл эдийн засгийн өсөлтөд гарах өөрчлөлтүүд нь голдуу 2-4 хувьд хэлбэлздэг юм. Урьдчилсан мэдээ бодитой байхын тулд бодит үзүүлэлтэдээ ойртсон байх ёстой.

Хэрэв та, өсөлтийн оргил үеийг ойлгоогүй юм бол яахаараа уналтыг нь сайн ойлгодог билээ?

Жилийн өмнө, Блю Чипийн дундаж зөвшилцсөн үзүүлэлт нь 2001 онд ДНБ-ний өсөлт 2,6 хувь хүрнэ гэж гарч байжээ. Бодитой өсөлт нь нэг орчим хувиар бага гарч болзошгүй боллоо. Хэрэв Есдүгээр сарын 11 буюу эдийн засагчдын урьдчилан харж чадаагүй зүйл уналтын шалтгаан болсон гэвэл таамаглагчдын уучилж болох юм гэж үү? Ийм өмгөөлөл нь бодит байдлаасаа ч илүү чанга сонсогдож мэдэх юм. Эдийн засгийн судалгааны үндэсний товчоо уналтыг хавар эрт эхэлсэн гэж үзэж байгаа юм.

Энэ бүхэн нь сэргэлтийн тухай урьдчилсан мэдээнд аль болох болгоомжтой хандаж байхыг сануулж байгаа юм. Дэлхийн II дайны дараахи уналт үүнтэй төстэй жишээ болж байгаа юм. Үүнд:

A-д нь эдийн засаг өргөжин хөгжиж байх үед инфляци өссөн;

Б-д инфляцийг багасгахын тулд Холбооны нөөцөөс хүүгийн хувь хэмжээг өсгөсөн;

В-д нь эдийн засгийн өсөлт саарч, бизнесийнхэнд хүсээгүй бараа материал хуримтлагддаг /илүүдэл хангамж, борлогдоогүй бүтээгдэхүүний үлдэгдэл/;

Г-д хүсээгүй бараа, материалыг багасгахын тулд компаниуд үйлдвэрлэлээ багасгаж ажилчдыг халж эхэлдэг;

Д-д нь үнэ ихтэй бараа материал болон ажилгүйдэл нь үнийг өсгөж, цалинг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Тэгээд инфляцийг хөөрөгдөнө;

Е-д нь Холбооны нөөц хүүгийн түвшинг зохицуулж, эдийн засгийн сэргэлт эхэлсэн жишээ байна. Энэ үйл явц гол төлөв нэг жилээс бага хугацаа шаарддаг аж. Дэлхийн II дайнаас хойш эдийн засгийн дундаж уналт 11 сар үргэлжилж байжээ.

Энэхүү хуваариар бол уналт төгсгөлдөө ойртож ирсэн байх учиртай аж. Бараг нэг жилийн өмнө эхэлсэн гэвэл сэргэлт эхлэх хугацаа нь болсон байх аж. Гэтэл энэ уналт ердийн жишгээр явахгүй нь бололтой. Үнэндээ 1999, 2000 онд инфляц маш багаар өссөн, Холбооны нөөцийн газраас хүүгийн түвшинг 1999 оны дунд үеэс өсгөж эхэлжээ. Гэвч эдийн засгийн гол бэрхшээлтэй асуудлуудыг инфляц, илүүдэл бараа материал байсан байгаагүйгээс үл хамааран богино хугацаанд хурдан эмчлэх боломжгүй юм.

1990-ээд оны эдийн засгийн хөөрлийн үед хэрэглэгчид зарлагаа хэтрүүлж, бизнесийнхэн хөрөнгө оруулалтын хойноос хөөцөлдөн дэлхий ертөнцийн бусад хэсэг Америкийн өсөлтөөр тэжээгдэн тэтгэгдэж байлаа. Хэрэглэгчид хадгаламжин дахь мөнгөө хоосолж, өр зээл тавьж, эсвэл хөрөнгийн биржийн хувьцааны ашигт найдан арилжаагаа идэвхжүүлж байв.

2001 оны эцсээр тэдний төлбөр тооцооны өр зээлийн хэмжээ, хувийн орлогын түвшинтэй нь харьцуулбал дээд цэгтээ хүрч, 14,3 хувийг эзлэх болжээ. Үүний нэгэн адил илүүдэл хамтарсан хөрөнгө оруулалт нь үйлдвэрийн ашиглагдаагүй үлдэх илүүдэл хүчин чадлыг асар их нэмэгдүүлсэн юм. АНУ-ын Холбооны нөөцийн газрын мэдээгээр илүүдэл хүчин чадал 1983 оноос хойш анх удаа дээд хэмжээнд хүрсэн байна.

Хамтарсан хөрөнгө оруулалт 2001 оны туршид буурав. 2000 оны эхээр хэрэглэгчдийн зарлага 5,9 хувийн хурдацтай өсөж байсан бол 2001 оны гуравдугаар улиралд өчүүхэн бага нэг хувь орчим өссөн дүнтэй гарчээ. Дээр нь Америк улс дэлхийн бусад газраас тусламж

авна гэсэн ойлголт байхгүй. Япон уналтад орчихсон, Европ бараг үүний дайтай байна. Аргентин өрөө төлөхөөс татгалзлаа, олонхи хөгжиж буй улсын эдийн засаг сулхан хэвээр байна. Энэ бүх хүчин зүйл АНУ-ын эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

2001 оны сүүлийн хоёр сард иений ханш 10 орчим хувиар унаж, 1998 оноос хойш анх удаа нэг доллар 130 иентэй тэнцэх болсон байна. Иений ханш ийнхүү унахыг Япон болон АНУ харилцан дэмжиж байсан бололтой. Энэ байдлыг Токиод тайлбарлахдаа эдийн засгийн бааз суурийн тусгал боллоо гэж байхад, АНУ Сангийн ямаараа дамжуулан иенийг худалдаж авах замаар мөнгөний зузаатгал хийхэд таатай орчин бий болгож байна хэмээн Вашингтонд тайлбарлаж байлаа.

Харамсалтай нь энэхүү бодит байдал нь валютын ханшийг цаашид тохиролцон зохицуулж байх үйл хэрэгт еврогийн гүйцэтгэж чадах үүрэг, байр суурийг үл тоомсорлосон хэрэг болсон юм. Иенийг ханшийг сулхан барьж байх гэсэн уг бодлого худалдааны гол түнш АНУ, Азийн бусад орны валютэд хүчтэй нөлөөлж эхэлвэл байдал бүтэлгүйтэх магадлалтай юм. Ийм учраас сүүлийн үед хүчээ авч буй еврогоор алдагдлыг тэнцвэржүүлэх боломжгүй байх болно.

Иений хүч сулрангуут Вашингтон үүнийг нь шууд хүлээн зөвшөөрсөн нь бас л сонирхолтой хэрэг. Өнгөрсөн оны зургадугаар сард АНУ-ын гол гол үйлдвэрлэгчид тэдний бараа бүтээгдэхүүн нь гадаадын зах зээлд очихдоо ханш ихтэй доллараас шалтгаалаад өндөр үнэтэй болж байна гэж Сангийн сайд Паул О'Нэйлдээ гомдоллож байжээ. Тэгсэн ч долларын гадаад ханш нэмэгдэх явдал үргэлжилсээр л байлаа. Есдүгээр сарын 11-ний халдлагын дараа Америкийн гадаад худалдаанд нөлөөлөх долларын ханш бусад гол валюттэй харьцуулбал өнгөрсөн онд найман хувь өсч, 2000 оныхоо амжилтуудыг баллах болсон юм.

1990-ээд оны турш АНУ-ын эдийн засаг хамгийн хямд бараа бүтээгдэхүүн болон капитал импортлон глобалчлалын ашиг тусыг асар ихээр хүртэж байсныг санах хэрэгтэй. Импорт нь 1980-аад оны эцсээр дотоодын эрэлт хэрэгцээнээс 20 орчим хувиар илүү байсан бол одоо 30 хувь болжээ. Тооцооны явцад үүсдэг алдагдлыг /дефицит/ гадаадын шууд болон үнэт цаасны багц хөрөнгө оруулалтаас унах цэвэр ашгаар бүрэн хаасаар иржээ.

Нөгөө талаар дэлхийн бусад улс АНУ-ын бараа бүтээгдэхүүний дотоодын өсөлт болон гадаадын капитал болсон тус улсын эдийн

засгаас маш ихээр хамаарч байдаг. 1990-ээд оны хоёрдугаар хагаст АНУ-ын импорт дангаараа Эдийн засгийн хамтын ажиллагаа нь хөгжингүй орнуудын импортын нийт өсөлтийн талыг бүрдүүлж байжээ. Дэлхийн бусад орон, ялангуяа Азийн орнуудын хувьд АНУ-аас ирэх бараа бүтээгдэхүүний эрэлт шаардлага багассан өнөө үед долларын ханш сулрах нь нэлээд хэцүү даваа болно гэсэн үг.

Шулуухан хэлбэл, АНУ-ын долларын ханш огцом унах нь дэлхийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлнэ. Гэхдээ энэ бол долларыг ямагт хүчтэй байлгахыг хүсч байдаг гэсэн үг биш юм. Нөгөө талаар долларын ханш өсөх явц нь хожим гэнэт огцом унаж, дэлхийн эдийн засгийн одоогийн бууралтыг бүр сүйрэлд хүргэх эрсдлийг ихэсгэж ч болзошгүй. Энэ бүхнийг урьчилан таамаглах аргагүй.

АНУ-ын засаг захиргаа цаашдаа иенийг "захиалгаар" сулруулах боломж байхгүй гэдгийг ч маш сайн ойлгож байгаа.

Дэлхийн валют солилцооны ханшийн тогтолцоог гурван талт хэмээн үзэх нь нэн зохимжтой. Нийтэд тархсан санаа бодлыг сөрж буй бодит үнэн гэвэл гадаад валютын зах зээлүүд дээр /солилцооны/ бий болсон тэнцвэргүй байдал нь АНУ-ын доллараас бус иен болон еврогоос урган гарч байгаа юм. Өнөөдрийн хувьд байдал 1980-аад оны дундуур Плазагийн гэрээний өмнөх шиг доллар бүх гол валютаас үлэмж өндөр ханштай байсан үеэс төсөөлөхийн аргагүй шал өөр болжээ.

Яг ийм үед евро хүчтэй байх нь дэлхийн эдийн засагт хоёр дахин их ач тусаа өгч болох шинж төлөв ажиглагдаж байна. Нэгдүгээрт, иенийг сулруулах шаардлагад саад болж буй зүйлүүдийг арилгана. Үүнийг онолын хувьд авч үзвэл Японы банкинд валютын ханшийг сулруулах боломж нь хязгааргүй. Хэрэгцээтэй хэмжээгээрээ цаасан мөнгө хэвлээд байж чадна. Гэвч амьдрал дээр долларын ханшийг огцом өсгөх эргүүлэгт оруулж, 1997-1998 онд Ази даяар гуйлга гуйсан хөршүүдийнхээ мөнгөний ханшийг унагааж эхэлвэл дээрх алхам сөргөөр нөлөөлөх нь мэдээж.

Тэгэхээр хүчтэй евро нь гадаад худалдаанд баримталдаг АНУ-ын болон Азийн орнуудын бусад валютын ханшийн солилцооны түвшинд нөлөөлөхгүйгээр иений ханшийг бууруулахад хүргэнэ. Үр дүн нь гэвэл гадаад худалдааны урсгалд нааштай нөлөөлж, АНУ болон Ази нь Японы худалдааны гол түншүүд хэвээрээ байх хэдий ч тэд евро бүс рүү одооноосоо илүү экспортлож, тэндээс Япон руу эргэх экспортыг нэмэгдүүлнэ.

Хоёрдугаарт, хүчтэй евро нь бага инфляц, зээлийн хүүгээрээ дамжуулан Европын дотоодын эрэлт хэрэгцээг эрс өсгөнө. Евро бүс нь ийм маягаар дэлхийн дахиныг сэргэлтэд илүү идэвхтэй үүрэг роль гүйцэтгэх боломжтой.

Энэ оны долдугаар сарын эхнээс Европын зах зээл дээр еврогийн ханш 0,98-0,99 ам.долларын хооронд хэлбэлзэж байв. Еврогийн ханш энэ оны эцэс гэхэд ам.долларыг давж, нэг евро 1.2 ам.доллартай тэнцэнэ гэж барууны гол шинжилгээ, судалгааны төв болон нэртэй шинжээчид үзэж байсан бол оросын шинжээчид 2-3 сарын дараа энэ бүхэн биелнэ гэж үзэж байна. Бидний сайн мэдэх дэлхийн топ санхүүчдийн нэг Жорж Сорос еврод хамгийн өндөр ач холбогдол өгч, удахгүй нэг евро 1,3 ам.доллартай тэнцэнэ гэж үзэж байна. Ам.долларын ханш ийнхүү хурдтай унаж байгаа нь Еврогийн гүйцэтгэх үүрэг ролийг улам бүр өргөж байна гэж үзэж болох юм.

АНУ-ын эдийн засгийн уналт ба баячууд

Америкийн эдийн засгийн уналт хүн амын хамгийн түрийвч зузаантай хэсгийнхнийг ч тойрсонгүй. "Forbes" сэтгүүлээс явуулсан судалгаанаас үзвэл АНУ-ын хамгийн баян 400 хүний хөрөнгө мөнгө 21 хувиар буурчээ. Гэхдээ баячуудын хэрэглэдэг бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн жилээс хойш бараг нэмэгдээгүй байна.

Америкийн "Forbes" сэтгүүл хамгийн баян хүмүүсийн амьдралын хэрэгцээт бүтээгдэхүүний үнэ өртгийг (The Cost of Living Extremely Well Index-CLEWI) судалж тооцоолох ажлыг 25 дахь жилдээ гүйцэтгэж байгаа билээ. Тус сэтгүүл баячуудын амьдрал ч мөн энгийн хүмүүсийн нэгэн адилаар эдийн засгийн нөлөөнд зайлшгүй өртдөг болохыг баталсаар ирсэн. "Forbes"-ийн мэдээлж буйгаар энэ онд Америкийн хамгийн баян 400 хүний хөрөнгө 1,2 триллионоос 948 тэрбум доллар хүртэл буурч, тансаг барааны үнэ бага нэмэгдэж зарим тохиолдолд бүр унасан гэсэн тооцоо гарчээ. 2000 онд CLEWI 2,6 хувиар өссөн бол 2001 онд 5,2 хувиар өссөн байсан билээ. Автомашины үнэ буурсан ч гэсэн ялангуяа Нью-Йорк, Вашингтонд автомашин худалдан авагчдын тоо эрс буурчээ.

Хоёр, гуравдугаар зэргийн шаардлагатай 42 нэрийн бүтээгдэхүүний гурав нь энэ онд илүү хямд байна. Парис хотын гурван одтой Michelin таван зочид буудлын нэг La Tour d'Argent-д дөрвөн хүний оройн зоог барихад 804 доллар. Энэ нь урьд оныхоос нэг хувиар бага байгаа юм. Louis Vuitton хэмээх эмэгтэйчүүдийн гар цүнхний үнэ

энэ онд 1,4 хувиар буурчээ. Одоо 10 доллар төлөөд тус цүнхний эзэн болж болох нь ээ!

Баячуудын хэрэглэдэг нийт тансаг бүтээгдэхүүнээс 12 барааны үнэ тогтвортой байв. Тухайлбал, Nautor's фирмийн Swan усан онгоц, Patek Philippe фирмийн эрэгтэй хүний алтан цаг мөн Hermes' Kelly-гийн эмэгтэй цүнх зэргийг дурдаж болно.

Гурван кг тугалын мах 189, Лос-Анжелест нэг кг хар түрс 2700, "Dom Perignon" оргилуун дарс 1500 долларын үнэтэй байгаа нь огт нэмэгдээгүй ханш гэлтэй.

Тэгвэл баячуудын мөнгө юунд илүү үрэгдээд байна вэ? Морин уралдааны хорхойтнууд энэ жил аваргын удамтай нэг настай морийг 710247 доллараар худалдан авч байсан нь урд оныхоос 14 хувиар өссөн ханш юм. Харин мөнхийн залуугаараа байхыг хүсэгчид нүүр болон хүзүүний арьсаа татуулахад 12500 доллар төлсөн нь өнгөрөгч оныхоос 1500 доллараар их байна.

Ийнхүү хөрөнгө нь багасах явдал баячуудыг сэтгэл зүйчид рүү хандах нөхцөлийг бий болгож болзошгүй хэмээн "Forbes" сэтгүүл үзэж байна. Гэвч сэтгэл зүйчдийн зүгээс баячуудыг өрөвдөх сэтгэл гаргахгүй бололтой. Яагаад гэвэл саяхан болтол баячууд мөнгөө хэрхэн үрэх тухай сэтгэл зүйчдэд байнга гомдоллодог байсан. Тийм ч учраас сэтгэл зүйчдийн үнэ ханш өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. Одоогийн байдлаар сэтгэл зүйч эмчид 45 минут үзүүлэхэд 240 доллар төлөх юм. Энэ ханш нь өнгөрсөн оныхоос есөн хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм байна.

АНУ-ын Төв банкнаас өнгөрсөн оны сүүлчээр хийсэн сүүлийн судалгаанаас үзэхэд тус улсын эдийн засаг тийм ч хурдан сэргэхгүй бололтой. Японы иентэй харьцах ам.долларын ханш унаж болзошгүй байна. АНУ-ын Төв банк өнгөрсөн арванхоёрдугаар сарын хуралдаанаараа (энэ жил 11 дэх удаагаа) хүүгийн хэмжээг дахин бууруулсан нь яваандаа долларын ханш унахад сөргөөр нөлөөлж болзошгүй юм. АНУ-ын гол гурван хөрөнгийн биржийн индекс нь бүгд 1,5 хувиас илүү унасан бөгөөд "Nasdaq Composite Index" 2,5 хувь буурч хувьцаа худалдан авах долларын эрэлтийг бууруулсан байна. АНУ-ын өнгөрсөн оны гуравдугаар улирлын ДНБ-ний урьдчилсан тооцоогоор (дэлхийн хамгийн том эдийн засаг) жилийн нэг хувийн бууралттай гарах төлөвтэй байна. "Blue Chip Economic Indicator"-ийн 51 эдийн засагч оролцсон судалгаанаас үзэхэд энэ оны дөрөвдүгээр улиралд эдийн засаг 1,9 хувийн уналттай гарна гэж тооцжээ.

АНУ-ын Төв банкны урьдчилсан судалгаа нь санхүүгийн дуулиант хэрэг гараагүй байх үе буюу терроризмын дараахан хийсэн судалгаа юм. Үйл явдлын өрнөлт дээрхи судалгаа, дүгнэлтээс ч хурдан эвгүй тал руугаа эргэж буйг бид өгүүллээ. АНУ-ын эдийн засгийн өсөлт удааширч буй хүчин зүйлийн нэг нь яах аргагүй терроризмтай холбогдоно. АНУ-ын батлан хамгаалахын жилийн төсөв нь 331 тэрбум ам.доллар байдаг. Терроризмтай тэмцэх зорилгоор АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш түүн дээр 48 тэрбум ам.доллар нэмж зарцуулах шийдвэр гаргасан нь хүндхэн байсан төсвийн алдагдалд хүчтэй нөлөөлсөн гэж шинжээчид үзэж байна. Зөвхөн нэмж гаргахаар болсон 48 тэрбум ам.доллар гэдэг маань Их Британи, Франц зэрэг хөгжингүй орнуудын батлан хамгаалахын жилийн төсвөөс илүү гарч байгаа юм.

Дэлхийн эдийн засгийн хөдөлгүүрийн үүрэг гүйцэтгэдэг Америкийн эдийн засаг хэдийгээр ийм баргар үзүүлэлттэй байгаа хэдий ч ард түмнийх нь оюуны потенциал, улс орных нь нөөц баялаг, хуримтлал агуу их юм. Энэ үүднээс авч үзвэл дээрхи үйл явц түр зуурын тохиолдлын шинжтэй гэж үзэж болох юм. Тиймдээ ч энэ оны тавдугаар сард Вашингтон хотноо болсон ОУВС, Дэлхийн банкны хаврын чуулган дээр Ерөнхийлөгч Ж.Буш "Ангалын улс орнууд" гэсэн шинэ нэр томъёолол бий болгож хөгжиж байгаа орнуудад үзүүлж буй зээл тусламжийнхаа хэмжээг нэмэгдүүлэхийг хөгжингүй орнуудад уриалж, энэ үйл явцад АНУ урьдын адил манлайлах үүрэг рольтой оролцохоо илэрхийлж, ирэх 3 жилийн хугацаанд таван тэрбум ам.долларыг жил болгон хөгжиж буй орнуудын хөгжилд зориулан гаргана гэдгээ амласан юм.

Олон улсын эдийн засгийн бодлогыг тодорхойлоход Америк тэргүүлэх үүрэгтэй. Дэлхийн хамгийн том эдийн засагтай улс орны хувьд АНУ нь ОУВС, Дэлхийн банкт хамгийн их нөлөөтэй. Америк эдгээр олон улсын байгууллага болон G-7 хэмээх үйлдвэржсэн орнуудаар дамжуулан мөн хоёр талын харилцаа холбоонд тулгуурлан өөрийн их гүрний үүрэг роль, байр сууриа хэвээр нь хадгалж үлдэх нь дамжиггүй.

Энэхүү өгүүлэл бичихдээ АНУ-ын "The economist", "NY Times", "The Mongol times", АНУ-ын Монгол Улсад суугаа ЭСЯ-ны мэдээллийн сэтгүүлийн энэ оны 1-7 сарын материалуудыг ашигласан болно.